



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/178

Улаанбаатар хот

Бакалаврын өдрийн хөтөлбөрт
2026-2027 оны хичээлийн жилийн намрын
улиралд оюутан элсүүлэх журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/143 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн "Босго оноо тогтоох тухай" А/34 дугаар тушаал, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн "Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрөөр оюутан элсүүлэхэд зохицуулалт хийх тухай" А/211 дугаар тушаал, МУИС-ийн дүрмийн 5.4.1, 5.4.8.9 дэх хэсэг, "МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журам"-ын 4.2.3 дахь хэсэг, МУИС-ийн ректорын зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 07, 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын их сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2026-2027 оны хичээлийн жилийн намрын улиралд оюутан элсүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаал гарсантай холбогдуулан элсэлтийн бодлого, журмыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газрын дарга (С.Булгантамир), Цахим шилжилтийн газрын дарга (А.Баатарбилэг) нарт үүрэг болгосугай.
3. Журмын дагуу элсэлтийн үйл ажиллагаа зохион байгуулахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар), Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газрын дарга (С.Булгантамир), Цахим шилжилтийн газрын дарга (А.Баатарбилэг), элсэлтийн комиссын гишүүдэд тус тус даалгасугай.
4. Элсэлтийн үйл ажиллагааны явц, үр дүн, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар)-д үүрэг болгосугай.


РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

1426131454

Монгол Улсын Их Сургуулийн ректорын
2026 оны 04 дүгээр сарын 06-ны/ний өдрийн
А/143 дугаар/дүгээр тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ 2026-2027 ОНЫ ХИЧЭЭЛИЙН
ЖИЛИЙН НАМРЫН УЛИРАЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Монгол Улсын Их Сургууль (цаашид МУИС гэнэ)-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2026-2027 оны хичээлийн жилийн намрын улиралд оюутан элсүүлэхэд Монгол Улсын "Дээд боловсролын тухай хууль", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/143 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", Боловсролын сайдын 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн "Босго оноо тогтоох тухай" А/34 дугаар тушаал, бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журам (цаашид журам гэнэ)-ыг баримтална.

1.2. МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг "бүртгүүлэгч", элсүүлэх оюутны тоог "хяналтын тоо", хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн цахим бүртгэлийн системийг "элсэлтийн систем", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг "элсэлтийн комисс" гэнэ.

1.3. МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт Улаанбаатар хот болон орон нутгаас элсүүлэх элсэгчийн хяналтын тоог МУИС-ийн удирдах зөвлөл тогтооно.

1.4. Элсэлтийн журам, бүрэлдэхүүн/салбар сургуульд элсэх Элсэлтийн Шалгалт (ЭШ)-ын босго оноо болон холбогдох бусад мэдээллийг <https://burtgel.num.edu.mn> элсэлтийн системд байршуулна.

1.5. МУИС-д гадаадын харьяат иргэнийг элсүүлэх асуудлыг "МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журам"-аар зохицуулна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС

2.1. МУИС-ийн ректорын тушаалаар МУИС-ийн элсэлтийн комиссыг томилно.

2.2. Элсэлтийн комиссын дарга элсэлтийг зохион байгуулах ажлыг удирдлагаар хангаж ажиллах бөгөөд журмаар зохицуулаагүй асуудлыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн саналыг үндэслэн комиссын хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

2.3. Бүртгэлийн хугацаа дууссаны дараа хяналтын тоо үлдсэн тохиолдолд элсэлтийн комисс нөхөн элсэлтийг цахимаар зохион байгуулж болно.

ГУРАВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

3.1. МУИС-д элсэхийг хүссэн иргэд энэхүү журамтай танилцаж, элсэлтийн системд бүртгүүлнэ.

3.2. Элсэлтийг нийслэл ба орон нутаг гэсэн хоёр бүсээр зохион байгуулна. Бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-өөс зохион байгуулдаг элсэлтийн шалгалт (ЭШ) өгсөн газрын харьяалагдах бүсэд өрсөлдөнө.

3.3. Ур чадварын шалгалттай хөтөлбөрийг сонгосон бүртгүүлэгч ур чадварын шалгалт өгнө.

3.4. Бүртгүүлэгч нь МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль (ШУС), Мэдээллийн технологи, электроникийн сургууль (МТЭС), Инженер, технологийн сургууль (ИТС), Бизнесийн сургууль (БС), Хууль зүйн сургууль (ХЗС), Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль (УТСОУХНУС), Завхан аймаг дахь МУИС-ийн Бизнес, мэдээллийн технологийн сургууль (Завхан аймаг дахь БМТС), МУИС-ийн Баруун бүсийн сургууль (Ховд, ББС), МУИС-ийн Зүүн бүсийн сургууль (Дорнод, ЗБС)-ийн хөтөлбөрөөс сонгож бүртгүүлнэ. ШУС-д бүртгүүлэгч нь Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Хүмүүнлэгийн ухааны салбарын хөтөлбөрөөс сонгоно.

3.5. Бүртгүүлэгч өөрийн хүсэлтээр бүрэлдэхүүн/салбар сургуулийн хэд хэдэн хөтөлбөрт бүртгүүлж болно.

3.6. Бүртгүүлэгч нь БҮТ-ийн хүчинтэй батламжтай, эсвэл 2026 онд ЭШ өгөхөөр БҮТ-д бүртгүүлсэн байна. Бүртгүүлэгч нь МУИС-ийн оюутан бол бүртгүүлэх боломжгүй.

3.7. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн Монгол Улсын иргэн БШУЯ-ны Сайдын 2024 оны 02 дугаар сарын 16-ны А/66 тоот тушаалаар баталсан "Элсэлтийн шалгалт болон монгол хэл, бичиг (цаашид суралцах чадварын шалгалт)-ийн шалгалт зохион байгуулах журам", Боловсролын сайдын 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/69 дүгээр тушаалыг баримтална.

ДӨРӨВ. ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ

4.1. Орон даяар МУИС-д элсэхийг хүссэн иргэд, цахим хэлбэрээр <https://burtgel.num.edu.mn> системийн бакалаврын өдрийн элсэлт хэсэгт бүртгүүлнэ.

4.2. Бүртгэлийг 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 09:00 цагт нээж, 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 12:00 цагт хаана.

4.3. Бүртгүүлэгч нь БҮТ-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан элсэлтийн системд нэвтэрнэ. Өмнө нь хэд хэдэн удаа ЭШ өгсөн бол сүүлийн бүртгэлийн дугаараар хүсэлт гаргаж бүртгүүлнэ. Системд шаардлагатай мэдээллээ үнэн зөв оруулж баталгаажуулна.

4.4. Бүртгүүлэгч нь элсэлтийн системд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг өөрөө хариуцах бөгөөд алдаатай, буруу мэдээлэл оруулснаас үүсэх асуудлыг МУИС хариуцахгүй.

4.5. Элсэлтийн системд нэвтрэх эрхтэй болсны дараа элсэх хүсэлт гаргах бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөр (тус журмын Хүснэгт 1-ээс үзэх)-өөс сонгож, бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлж баталгаажуулна. (Төлбөр төлөх тухай дэлгэрэнгүй зөвлөмжийг элсэлтийн системээс үзнэ үү).

4.6. Бүртгэлийн хураамжийг нэг удаа төлж, бүрэлдэхүүн/салбар сургуулийн хэд хэдэн хөтөлбөрт бүртгүүлэх боломжтой. Бүртгэлийн хураамжийг МУИС-ийн Удирдах зөвлөлөөс баталсан "Үйлчилгээний бусад хураамжийн хэмжээ"-д заасны дагуу авна. Бүртгэлийн хураамжийг буцааж олгохгүй.

ТАВ. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ

5.1. Бүртгүүлэгчийн ЭШ-ын дүн болон бусад мэдээллийг БҮТ-өөс элсэлтийн системд татан авч, холбогдох тооцооллыг хийж, онооны жагсаалтыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөр бүрээр элсэлтийн бүртгэл хааснаас 1 өдрийн дараа гаргана.

5.2. Улаанбаатар хот дахь МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн хувьд "Суурь" болон "Дагалдах" шалгалтын оноо тус бүр 490, орон нутгийн салбар сургуулийн хувьд 430 онооноос багагүй байна. Суурь шалгалтад тооцуулсан хичээлийн оноог дагалдах шалгалтад давхар тооцохгүй.

5.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрэлттэй, тэргүүлэх чиглэл болон мэргэжлийн чиглэл (хөтөлбөрийн нэр) 05-09-д заасан ерөнхий чиглэлд хамаарах хөтөлбөрөөр элсэгчид тавигдах ЭШ-ын шаардлагад өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан тохиолдолд элсэлтийн төв комиссоос уг шийдвэрийн дагуу зохицуулалтыг хийнэ.

5.4. Бүртгүүлэгчийн оноог дараах байдлаар тооцно. "Суурь" шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.7, "Дагалдах" шалгалтад тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.3-аар үржүүлж, нэмсэн нийлбэрээр тооцоолсон оноог бодно. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөр, хамтарсан хөтөлбөрийн тооцоолсон онооны босгыг тус журмын Хүснэгт 1-д заасныг баримтална.

5.5. Тооцоолсон оноо тэнцсэн тохиолдолд ЭШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцон байр эзлүүлж, элсэх эрх олгох бөгөөд гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноо, суурь хичээлийн оноо, суурь хичээлийн гүйцэтгэл, монгол хэл бичгийн оноо, монгол хэл бичгийн гүйцэтгэл, ЭШ-ын дундаж оноог харгалзана. ЭШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцохдоо энэ журмын 5.4-т заасан аргачлалын дагуу тооцно.

5.6. Ур чадварын шалгалт бүхий хөтөлбөрийн хувьд ур чадварын шалгалтыг тухайн Ур чадварын шалгалтын удирдамж /Хавсралт/-ийн дагуу бүрэлдэхүүн/салбар сургууль дээр зохион байгуулна. Ур чадварын шалгалтыг 100 хүртэл оноогоор үнэлнэ. Уг оноог хэмжээст оноонд дараах байдлаар харгалзуулна.

№	Шалгалтын оноо /Анхны оноо-А/	Хэмжээст оноо
1	95-100	760-800
2	90-94.9	720-759
3	85-89.9	680-719
4	80-84.9	640-679
5	75-79.9	600-639
6	70-74.9	560-599
7	65-69.9	520-559
8	60-64.9	490-519
9	0-59	200-489

5.7. Ур чадварын шалгалтын хэмжээст оноог дагалдах шалгалтын оноогоор тооцно. Шалгуулагчийн анхны оноо 0-ээс 59-ийн хооронд бол $X=200+A*4.66$ Хэрэв шалгуулагчийн анхны оноо 60-аас 100-ын хооронд бол $X=490+(A-60)*8$ гэсэн томъёогоор олно. 60 буюу 490 болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

5.8. Бүртгүүлэгч нь сүүлийн 2 жилийн дотор дараах шаардлагыг хангаж байвал шилдэг элсэгч гэж үзэж, албан ёсны эрх бүхий байгууллагаас олгосон батламж, сертификат, баримт бичигт үндэслэн хяналтын тоонд багтаан элсүүлнэ. Үүнд:

- 5.8.1. Боловсролын яамнаас тогтоосон Олон улсын болон Улсын олимпиадад оролцож энэ журмын Хүснэгт 2-т заасан нөхцөлийг хангасан ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчийг тухайн олимпиадын чиглэлийн хөтөлбөрт, Электроникийн улсын олимпиадад онооны эрэмбээр 1-ээс 11-рт жагссан оролцогчийг “Электроникийн инженерчлэл” хөтөлбөр, Статистикийн олимпиадад онооны эрэмбээр 1-ээс 11-рт жагссан оролцогчийг “Статистик” хөтөлбөрт тус тус шууд элсүүлнэ.
- 5.8.2. Англи хэлний олон улсын шалгалтын IELTS 5, TOEFL iBT 45, PTE 40.8-аас дээш оноотой бүртгүүлэгчдийг гүйцэтгэлийн хувиар жагсааж, эхний 10 байр эзэлсэн бүртгүүлэгчийг ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарт шууд элсүүлнэ.
- 5.8.3. Кембрижийн олон улсын AS (A) түвшний шалгалтын b (B) -ээс дээш, IB (international baccalaureate) хөтөлбөрийн 4-өөс дээш үнэлгээтэй бүртгүүлэгчдийг сургууль бүрд суурь шалгалтад тооцохоор заасан хичээлээр нь онооны дарааллаар жагсаан, эхний 3 байр эзэлсэн бүртгүүлэгчийг шууд элсүүлнэ.
- 5.8.4. Комиссын зүгээс спортын өндөр ур чадвартай 10 хүртэлх бүртгүүлэгчийг шалгаруулахдаа мэргэжлийн тэнхимийн багш нарын саналыг үндэслэж, гэрээ байгуулж БС (хяналтын тоо-2), МТЭС (хяналтын тоо-2), ШУС, ИТС, ББС, ЗБС, ЗАдБМТС-д элсүүлж болно (Олимп, тив, дэлхийн тэмцээнээс медальт болон шагналт байранд шалгарсан, улсын өсвөр үеийн, улсын идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байранд шалгарсан бүртгүүлэгчдийг гаргасан амжилтаар нь эрэмбэлж сонгуулна).

5.9. Шилдэг элсэгч нь тухайн бүрэлдэхүүн/салбар сургуулийн суурь болон дагалдах шалгалтад тооцохоор заасан хичээлүүдээс ЭШ өгсөн байх ба МУИС-аас тавих ЭШ-ын босго оноог хангасан байна.

5.10. МУИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн төгсөгчийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн суурь болон дагалдах шалгалтад тооцохоор заасан хичээлүүдээс ЭШ өгч, тухайн хөтөлбөрийн тооцоолсон босго оноог хангасан бол ШУС-ийн Байгалийн ухааны салбар, Инженер, технологийн сургуулийн хөтөлбөрүүдэд шууд элсүүлнэ. Мэдээллийн технологи, электроникийн сургуульд элсэх нөхцөлд ЭШ-ын тооцоолсон босго оноо 550 ба түүнээс дээш байна.

5.11. МУИС-ийн харьяа орон нутгийн ерөнхий боловсролын ахлах сургуулийн төгсөгчийг тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн суурь болон дагалдах шалгалтад тооцохоор заасан хичээлүүдээс ЭШ өгч, БЯ-наас баталсан их сургуульд элсэгчдийн хангасан байх босго оноо болон тухайн хөтөлбөрийн тооцоолсон босго оноог хангасан бол дор заасан сургуулийн сонгосон хөтөлбөрт шууд элсүүлнэ. Үүнд:

- 5.11.1. МУИС-ийн харьяа Дорнод аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургуулийн энэхүү журмын 5.11-д заасан ерөнхий шаардлагыг хангасан төгсөгчийн хувьд ШУС-ийн Байгалийн ухааны салбарын энэ журмын хүснэгт 3-т заасан хөтөлбөрүүд, Инженер, технологийн сургууль, Зүүн бүсийн салбар сургуулийн сонгосон хөтөлбөрт,

- 5.11.2. МУИС-ийн харьяа Завхан аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургуулийн энэхүү журмын 5.11-д заасан ерөнхий шаардлагыг хангасан төгсөгчийн хувьд МУИС-ийн Бизнесийн сургууль (тооцоолсон босго оноо 550 ба түүнээс дээш байх), ЗАдБМТС-ийн сонгосон хөтөлбөрт,
- 5.11.3. МУИС-ийн харьяа Ховд аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургуулийн энэхүү журмын 5.11-д заасан ерөнхий шаардлагыг хангасан төгсөгчийн хувьд ШУС-ийн Байгалийн ухааны салбарын энэ журмын хүснэгт 3-т заасан хөтөлбөрүүд, Инженер, технологийн сургууль, Баруун бүсийн салбар сургуулийн сонгосон хөтөлбөрт шууд элсүүлнэ.

5.12. Тус журмын 5.8.1-5.8.4, 5.9, 5.10, 5.11 дэх нөхцөлийг хангасан бүртгүүлэгч “Олимпиад”, “Англи хэлний олон улсын шалгалт”, “Кембриж, IV-ийн олон улсын шалгалт”, “Спортын ур чадвар”, “МУИС-ийн харьяа ерөнхий боловсролын сургууль”, “МУИС-ийн орон нутгийн ерөнхий боловсролын сургууль” гэсэн ангиллаас сонгон, энэ журмын 4.5-д заасан бүртгэлийн хураамж төлж, тухайн нөхцөл хангасныг гэрчлэх бичиг баримтын хуулбарыг, өргөдлийн хамт энэхүү журмын 4.2-т заасан бүртгэлийн хугацаа хаахаас 7 хоногийн өмнө (2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 17:30 минут) бүртгэлийн системээр илгээж бүртгүүлнэ.

ЗУРГАА. ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ

6.1. Орон даяар элсэх эрх олгох үйл ажиллагааг цахим хэлбэрээр <https://burtgel.num.edu.mn> системээр явуулна.

6.2. Бүртгүүлэгч хяналтын тоонд багтсан эсэхээ онооны жагсаалт гарсны дараа элсэлтийн системд нэвтэрч шалгана.

6.3. Шилдэг элсэгч ангиллын шалгаруулалтад тэнцсэн болон лицей ахлах сургуулийг төгссөн бүртгүүлэгч нь заасан хугацаанд элсэн суралцах бүрэлдэхүүн/салбар сургуулийн ерөнхий суурь хичээлийн 1 багц цагийн төлбөрийг төлж элсэх эрхээ баталгаажуулна.

6.4. Элсэх эрх олгох үйл ажиллагааг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 12:00 цагт эхлүүлж, 2026 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 12:00 цагт дуусгана.

6.5. Хэд хэдэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөрийн хяналтын тоонд багтсан элсэгч нь зөвхөн нэг бүрэлдэхүүн/салбар сургуулийн нэг хөтөлбөр сонгоно. Сонгомогц бусад бүрэлдэхүүн/салбар сургуулийн хяналтын тооны жагсаалтаас бүртгүүлэгчийн нэрийг хасаж, босго шугамыг нэгээр доошлуулна. Босго шугам доошилсны дүнд хяналтын тоонд багтсан дараагийн бүртгүүлэгчид элсэх эрх үүснэ.

6.6. Бүртгүүлэгч хяналтын тоонд багтаж элсэх эрхтэй болсноос хойш ¹ (нэг цагийн дотор элсэх эрхээ баталгаажуулна. Энэ хугацаанд баталгаажуулаагүй тохиолдолд МУИС-д элсэхээс татгалзсан гэж үзэж, жагсаалтад байгаа дараагийн бүртгүүлэгчдэд элсэх эрхийг шилжүүлнэ.

6.7. Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч журмын 6.6-д заасан хугацаанд элсэлтийн системд нэвтэрч, элсэн суралцах бүрэлдэхүүн/салбар сургуулийн ерөнхий суурь хичээлийн 1 багц цагийн төлбөрийг төлж, элсэх эрхээ баталгаажуулна.

6.8. Элсэх эрхээ баталгаажуулсан төлбөрийг суралцагчийн сургалтын төлбөрт оруулан тооцно. Элсэх эрхээ цуцлах тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй².

¹ Комиссын шийдвэрээр эрх баталгаажуулах хугацааг өөрчилж болно.

² Хуваарь буцааснаар дараагийн бүртгүүлэгч хуваарь авч чадахгүйд хүрч, эрх ашиг нь хөндөгддөг тул хариуцлагатай сонголт хийлгэх үүднээс урьдчилж төлүүлдэг.

ДОЛОО. ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ

7.1. Элсэгч нь 2026 оны 07 дугаар сарын 31-ний 15:00 цаг хүртэл <https://burtgel.num.edu.mn> системийн бакалаврын өдрийн элсэлт хэсэгт нэвтэрч маягт бөглөж, "МУИС-д суралцагч суралцуулах гэрээ"-г зөвшөөрсөн эсэхээ баталгаажуулж, цахим хэлбэрээр бүртгүүлж, оюутан болох хүсэлт илгээн, оюутны хувийн дугаар, нууц үг авна.

7.2. Энэ журмын 7.1-д заасан хугацаанд оюутан болж бүртгүүлээгүй тохиолдолд МУИС-д элсэхээс татгалзсан гэж үзнэ.

НАЙМ. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТ, ТЭТГЭЛЭГ

8.1. Боловсролын яамнаас тогтоосон Олон улсын болон улсын олимпиадад оролцож, онооны эрэмбээр 1-ээс 3-т жагссан элсэгчид сургалтын төлбөрийн 50-100 хувийн хөнгөлөлт үзүүлнэ. Үүнд:

- 8.1.1. Олон улсын олимпиадад оролцож, онооны эрэмбээр 1-ээс 3-т жагссан элсэгчид 100 хувь;
- 8.1.2. Улсын олимпиадад оролцож, онооны эрэмбээр 1-т жагссан элсэгчид 100 хувь;
- 8.1.3. Улсын олимпиадад оролцож, онооны эрэмбээр 2-т жагссан элсэгчид 75 хувь;
- 8.1.4. Улсын олимпиадад оролцож, онооны эрэмбээр 3-т жагссан элсэгчид 50 хувь.

8.2. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 103 дугаар тогтоол "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ын 2.1-2.7 дах заалтын тавигдах шаардлагыг хангасан бол төрөөс төлбөрийг бүрэн санхүүжүүлнэ.

8.3. Монголын сайхан бичигтэн уралдаанаас шалгарсан, суралцах эрх (ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын хөтөлбөрүүдээс сонгоно) авсан элсэгчийн суралцах хугацааны сургалтын төлбөрийг Засгийн газрын буцалтгүй тэтгэлгээр 100 хувь олгоно.

8.4. Орон нутгийн салбар сургуулиуд бие даасан тэтгэлэг, хөнгөлөлтийн нөхцөлтэй байж болно.

8.5. Элсэгчдэд олгох тэтгэлгийг эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрт багтааж "МУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох журам"-аар зохицуулна.

ЕС. ЭШ-ЫН ОНОО ШААРДАХГҮЙГЭЭР БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ ЭЛСҮҮЛЭХ

9.1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны А/143 дугаар тушаалаар баталсан "Оюутан элсүүлэх журам"-ын 2.4 дэх заалтын шалгуурыг хангасан иргэнээс ЭШ-ын оноо шаардахгүй элсүүлнэ.


9.2. Журмын 9.1-д заасан иргэн <https://burtgel.num.edu.mn> бүртгэлийн нэгдсэн систем хэсэгт бүртгүүлнэ. Бүртгэлийг 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 09:00 цагт нээж, 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 12:00 цагт хаана.

9.3. Бүртгүүлэгч нь тус журмын хүснэгт 1-т заасан бакалаврын үндсэн мэргэжлийн хөтөлбөрийн жагсаалтаас сонгон бүртгүүлнэ.

9.4. Бүртгүүлэгч нь элсэлтийн системд шаардлагатай мэдээллийг оруулж, элсэх хүсэлтээ гаргаж, бүртгэлийн хураамжийг төлнө.

9.5. Бүртгүүлэхдээ элсэлтийн систем дэх анкетыг бөглөж, дараах бичиг баримтыг цахим хэлбэрээр хавсаргана. Үүнд:

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (гадаад паспорт)
- Өмнө нь эзэмшсэн боловсролын диплом, хавсралтын хамт (Гадаад хэлээр бол Монгол хэл рүү орчуулан нотариатаар гэрчлүүлсэн байна)
- Цээж зураг (Сүүлийн 3 сард авхуулсан, 3x4 хэмжээтэй)



9.6. Улаанбаатар хотоос хөтөлбөр бүрд элсүүлэх хяналтын тооны 10 хүртэлх хувьд ЭШ-гүйгээр элсүүлнэ. ШУС-ийн Байгалийн ухааны салбар, Хүмүүнлэгийн ухааны салбарын хөтөлбөрүүд, ИТС-ийн "Ойн аж ахуй" хөтөлбөр ба Орон нутгийн салбар сургуулиудад хөтөлбөрт элсэх хяналтын тоо заахгүй.

9.7. Элсэлтийн комисс нь бүртгүүлэгчийн тоо хяналтын тооноос хэтэрсэн тохиолдолд харьяалагдах тэнхимтэй хамтарч шалгалт зохион байгуулж шалгаруулна.

9.8. Элсэх эрх олгох үйл ажиллагааг 2026 оны 06 дугаар сарын 19-ний дотор зохион байгуулна.

9.9. Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч бүрэлдэхүүн/салбар сургуулийн ерөнхий суурь хөтөлбөрийн 1 багц цагийн төлбөрийг төлж элсэх эрхээ баталгаажуулна. Элсэх эрхээ цуцлах тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй.

9.10. Элсэгч нь 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 15:00 цаг хүртэл <https://burtgel.num.edu.mn> бүртгэлийн нэгдсэн системээр нэвтэрч "МУИС-д суралцагч суралцуулах гэрээ"-г зөвшөөрсөн эсэхээ баталгаажуулж, цахим хэлбэрээр бүртгүүлж, оюутан болох хүсэлт илгээж, оюутны хувийн дугаар, нууц үг авна. Бүртгүүлээгүй тохиолдолд элсэх эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

9.11. Хичээл дүйцүүлэхтэй холбоотой асуудлыг "МУИС-д хичээл дүйцүүлэх журам"-аар зохицуулна.

АРАВ. БУСАД

10.1. Орон нутгийн салбар сургуулийн элсэлтийг нэмэлтээр уламжлалт хэлбэрээр 2026 оны 08 дугаар сарын 20 хүртэл зохион байгуулж болно.

10.2. Бүртгэлийн хураамжийг илүү төлсөн, элсэх эрхээ баталгаажуулаагүй бүртгүүлэгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн илүү төлсөн бүртгэлийн хураамж, баталгаажуулах төлбөрийг буцааж олгоно. Бүртгүүлэгч төлбөр буцаан авах хүсэлтээ 08 дугаар сарын 31-ний дотор гаргана. Энэ хугацаанаас хойш төлбөр буцаах хүсэлт хүлээж авахгүй.

10.3. Бүртгүүлэгч нь энэхүү элсэлтийн журамтай биечлэн танилцсан байх үүрэгтэй.


10.4. Элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой гомдол маргааныг элсэлтийн комисс шийдвэрлэнэ.


10.5. МУИС-ийн 2026-2027 оны хичээлийн жилийн бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэлтийг мэргэжлийн хөтөлбөрөөр авч байгаа нь Боловсролын сайдын 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн "Босго оноо тогтоох тухай" А/34 дугаар тушаалыг хэрэгжүүлж байгаа хэрэг бөгөөд энэ нь МУИС-д уламжлал болон тогтоод байгаа либерал арт сургалтын үйл ажиллагаанд нөлөөлөхгүй болно.

БҮРЭЛДЭХҮҮН/САЛБАР СУРГУУЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР,
ХАРГАЛЗАХ СУУРЬ БОЛОН ДАГАЛДАХ ШАЛГАЛТЫН ЖАГСААЛТ


№	БАКАЛАВРЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨР /121 багц цаг (ХЗС-ийн хувьд 151 багц цаг)/	ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ		ТООЦООЛ- СОН ОНООНЫ БОСГО
		"СУУРЬ" шалгалт (70%)	"ДАГАЛДАХ" шалгалт (30%)	
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР				
1.	1. Багш, математикийн боловсрол**	· Математик · Физик	· Ур чадварын шалгалт	490
2.	2. Багш, химийн боловсрол**	· Хими · Математик · Биологи	· Ур чадварын шалгалт	
3.	3. Багш, биологийн боловсрол**	· Биологи · Хими	· Ур чадварын шалгалт	
4.	4. Багш, физикийн боловсрол**	· Физик · Математик	· Ур чадварын шалгалт	
5.	5. Багш, газарзүйн боловсрол**	· Газарзүй · Нийгэм судлал · Математик	· Ур чадварын шалгалт	
6.	6. Биологи*	· Биологи · Математик	· Хими · Англи хэл · Монгол хэл	
7.	7. Биохими	· Биологи · Математик	· Хими · Англи хэл	
8.	8. Биотехнологи*	· Биологи · Математик	· Хими · Англи хэл	
9.	9. Экологи	· Биологи · Математик	· Хими · Нийгэм судлал	
10.	10. Биологийн нөөц судлал	· Биологи · Математик	· Хими · Нийгэм судлал	
11.	11. Хими*	· Хими · Математик	· Биологи · Англи хэл	
12.	12. Хэрэглээний хими	· Хими · Математик	· Биологи · Англи хэл	
13.	13. Газар зүй*	· Газарзүй · Математик	· Физик · Англи хэл	

14.	14. Геологи*	· Математик · Физик	· Газарзүй · Англи хэл · Хими		
15.	15. Геофизик	· Математик · Физик	· Газарзүй · Англи хэл		
16.	16. Байгаль орчны зайнаас тандан судлал	· Математик · Физик · Газарзүй	· Нийгэм судлал · Англи хэл		
17.	17. Цаг уур судлал	· Математик · Физик · Газарзүй	· Нийгэм судлал · Англи хэл · Монгол хэл		
18.	18. Ус судлал	· Математик · Физик · Газарзүй	· Нийгэм судлал · Англи хэл · Монгол хэл		
19.	19. Физик*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл		
20.	20. Математик*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл		
21.	21. Физик электроник	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл		
22.	22. Газар зохион байгуулалт	· Математик · Газарзүй	· Англи хэл · Физик		
23.	23. Хот ба бүс нутгийн төлөвлөлт*	· Математик · Физик · Газарзүй	· Нийгэм судлал · Англи хэл		
24.	24. Аялал жуулчлал**	· Газарзүй · Математик · Англи хэл	· Ур чадварын шалгалт		
25.	25. Микробиологи	· Биологи · Математик	· Хими · Англи хэл		
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР					
26.	1. Антропологи	· Түүх · Нийгэм судлал	· Монгол хэл · Англи хэл		490
27.	2. Археологи	· Түүх · Математик	· Нийгэм судлал · Монгол хэл		
28.	3. Хүн ам зүй	· Нийгэм судлал · Математик	· Түүх · Англи хэл		


29.	4. Нийгмийн ажил**	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Англи хэл 	<ul style="list-style-type: none"> · Монгол хэл · Математик 	
30.	5. Социологи	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	<ul style="list-style-type: none"> · Математик · Англи хэл 	
31.	6. Сэтгүүл зүй	<ul style="list-style-type: none"> · Монгол хэл · Англи хэл · Нийгэм судлал 	<ul style="list-style-type: none"> · Ур чадварын шалгалт 	
32.	7. Сэтгэл судлал**	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Математик 	<ul style="list-style-type: none"> · Монгол хэл · Англи хэл 	
33.	8. Эдийн засаг	<ul style="list-style-type: none"> · Математик 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Англи хэл 	
34.	9. Олон нийтийн харилцаа, мэдээлэл	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Англи хэл 	<ul style="list-style-type: none"> · Түүх · Монгол хэл 	
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР				
35.	1. Гадаад хэлний орчуулга (Англи)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл · Математик 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Монгол хэл · Түүх 	490
36.	2. Гадаад хэлний орчуулга (Герман)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл · Математик 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Монгол хэл · Түүх 	
37.	3. Гадаад хэлний орчуулга (Орос)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл · Математик 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Монгол хэл · Түүх 	
38.	4. Гадаад хэлний орчуулга (Солонгос)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл · Математик 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Монгол хэл · Түүх 	
39.	5. Гадаад хэлний орчуулга (Турк)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл · Математик 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Монгол хэл · Түүх 	
40.	6. Гадаад хэлний орчуулга (Франц)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл · Математик 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Монгол хэл · Түүх 	
41.	7. Гадаад хэлний орчуулга (Хятад)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл · Математик 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Монгол хэл · Түүх 	


42.	8. Гадаад хэлний орчуулга (Япон)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл · Математик 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Монгол хэл · Түүх 	
43.	9. Гадаад хэлний орчуулга (Араб)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл · Математик 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Монгол хэл · Түүх 	
44.	10. Олон улс, орон судлал (Америк)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
45.	11. Олон улс, орон судлал (Испани)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
46.	12. Олон улс, орон судлал (Итали)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
47.	13. Олон улс, орон судлал (Их Британи)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
48.	14. Олон улс, орон судлал (Солонгос)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
49.	15. Олон улс, орон судлал (Турк)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
50.	16. Олон улс, орон судлал (Франц)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
51.	17. Олон улс, орон судлал (Хятад)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
52.	18. Олон улс, орон судлал (Чех)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
53.	19. Олон улс, орон судлал (Польш)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
54.	20. Олон улс, орон судлал (Япон)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
55.	21. Олон улс, орон судлал (Араб)	<ul style="list-style-type: none"> · Англи хэл · Орос хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	
56.	22. Утга зохиол судлал	<ul style="list-style-type: none"> · Монгол хэл · Англи хэл 	<ul style="list-style-type: none"> · Нийгэм судлал · Түүх 	

57.	23. Урлаг судлал	· Монгол хэл · Түүх	· Нийгэм судлал · Англи хэл	
58.	24. Хэл, уран зохиол (Монгол)	· Монгол хэл · Нийгэм судлал	· Түүх · Англи хэл	
59.	25. Хэл шинжлэл (Монгол)	· Монгол хэл · Нийгэм судлал	· Түүх · Англи хэл	
60.	26. Хэл шинжлэл (Орос)	· Монгол хэл · Нийгэм судлал	· Түүх · Англи хэл	
61.	27. Хэл шинжлэл (Хятад) 28. Хэл шинжлэл (Хятад) 2+2 хамтарсан	· Монгол хэл · Нийгэм судлал	· Түүх · Англи хэл	
62.	29. Хэл шинжлэл (Герман)	· Монгол хэл · Нийгэм судлал	· Түүх · Англи хэл	
63.	30. Багш, гадаад хэлний боловсрол (Англи)	· Англи хэл · Орос хэл · Монгол хэл	· Ур чадварын шалгалт	
64.	31. Багш, гадаад хэлний боловсрол (Орос)	· Англи хэл · Орос хэл · Монгол хэл	· Ур чадварын шалгалт	
65.	32. Түүх	· Түүх · Нийгэм судлал	· Газарзүй · Монгол хэл · Англи хэл	
66.	33. Философи	· Нийгэм судлал · Математик	· Монгол хэл · Түүх · Англи хэл	
67.	34. Шашин судлал	· Түүх · Нийгэм судлал · Англи хэл	· Монгол хэл · Математик	
68.	35. Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадварын шалгалт	
69.	36. Багш, нийгмийн ухааны боловсрол (Түүх)	· Нийгэм судлал · Түүх	· Ур чадварын шалгалт	
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ЭЛЕКТРОНИКИЙН СУРГУУЛЬ				
70.	1. Компьютерын ухаан*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	490
71.	2. Мэдээллийн технологи*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	

72.	3. Программ хангамж**	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
73.	4. Мультимедиа технологи	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
74.	5. Мэдээллийн систем	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
75.	6. Статистик*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
76.	7. Хэрэглээний математик	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
77.	8. Электроникийн инженерчлэл*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
78.	9. Компьютерын сүлжээ	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
79.	10. Холбооны технологи	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
80.	11. Компьютерын инженерчлэл	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
81.	12. Хиймэл оюун	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ				
82.	1. Сэргээгдэх эрчим хүч*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	490
83.	2. Цөмийн инженерчлэл	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
84.	3. Био-инженерчлэл*	· Математик · Физик · Биологи	· Хими · Англи хэл	
85.	4. Материал судлал, инженерчлэл*	· Математик · Хими · Физик	· Англи хэл · Нийгэм судлал	
86.	5. Нано шинжлэх ухаан, инженерчлэл*	· Математик · Хими	· Физик · Англи хэл	
87.	6. Химийн инженерчлэл*	· Хими · Математик	· Физик · Англи хэл	


88.	7. Хүрээлэн буй орчны инженерчлэл*	· Математик · Хими · Физик	· Биологи · Англи хэл	
89.	8. Химийн боловсруулалтын технологи	· Хими · Физик · Математик	· Англи хэл · Биологи	
90.	9. Хүрээлэн буй орчин судлал	· Хими · Математик	· Биологи · Нийгэм судлал	
91.	10. Ойн аж ахуй*/**	· Хими · Физик · Биологи	· Математик · Нийгэм судлал	
92.	11. Ашигт малтмалын баяжуулалтын технологи*	· Хими · Физик · Математик	· Газарзүй · Нийгэм судлал	
БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ				
93.	1. Нягтлан бодох бүртгэл	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	490
94.	2. Санхүү, банк	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	
95.	3. Даатгал	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	
96.	4. Маркетинг	· Математик	· Нийгэм судлал · Англи хэл	
97.	5. Менежмент	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	
98.	6. Худалдаа	· Нийгэм судлал	· Монгол хэл · Англи хэл	
99.	7. Зочлох үйлчилгээ	· Нийгэм судлал	· Монгол хэл · Түүх	
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ				
100.	1. Эрх зүй	· Нийгэм судлал	· Математик · Англи хэл	490
УЛС ТӨР СУДЛАЛ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ				
101.	1. Олон улсын харилцаа	· Англи хэл · Орос хэл	· Нийгэм судлал · Түүх	490
102.	2. Нийтийн удирдлага	· Нийгэм судлал · Математик	· Англи хэл · Нийгэм судлал	




103.	3. Улс төр судлал	· Нийгэм судлал · Математик	· Түүх · Англи хэл		
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ МУИС-ийн БИЗНЕС, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ					
104.	1. Нягтлан бодох бүртгэл	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал		
105.	2. Санхүү, банк	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал		
106.	3. Маркетинг	· Математик	· Нийгэм судлал · Англи хэл		
107.	4. Менежмент	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал		
108.	5. Худалдаа	· Нийгэм судлал	· Монгол хэл · Англи хэл	430	
МУИС-ийн ЗҮҮН БҮСИЙН СУРГУУЛЬ					
109.	1. Гадаад хэлний орчуулга (Хятад)	· Англи хэл · Орос хэл · Математик	· Нийгэм судлал · Монгол хэл · Түүх	430	
110.	2. Түүх	· Түүх · Нийгэм судлал	· Газарзүй · Монгол хэл · Англи хэл		
111.	3. Нягтлан бодох бүртгэл	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал		
112.	4. Бизнесийн удирдлага	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал		
113.	5. Газрын тосны инженерчлэл*	· Математик · Физик · Хими	· Англи хэл · Нийгэм судлал		
114.	6. Цаг уур судлал	· Математик · Физик · Газарзүй	· Нийгэм судлал · Англи хэл · Монгол хэл		
115.	7. Нийгмийн ажил**	· Нийгэм судлал · Англи хэл	· Монгол хэл · Математик		
116.	8. Аялал жуулчлал**	· Газарзүй · Математик · Англи хэл	· Ур чадвар		
117.	9. Сэтгэл судлал**	· Нийгэм судлал · Математик	· Монгол хэл · Англи хэл		
118.	10. Мэдээллийн технологи*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл		
119.	11. Багш, дизайн технологийн боловсрол	· Математик · Нийгэм судлал · Монгол хэл	· Ур чадварын шалгалт		

120.	12. Багш, дизайн зураг зүйн боловсрол	· Нийгэм судлал · Математик	· Ур чадварын шалгалт	
121.	13. Багш, дүрслэх урлагийн боловсрол	· Математик · Нийгэм судлал · Монгол хэл	· Ур чадварын шалгалт	
122.	14. Багш, биеийн тамирын боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадварын шалгалт	
123.	15. Багш, сургуулийн өмнөх боловсрол**	· Математик · Нийгэм судлал · Монгол хэл	· Ур чадварын шалгалт	
124.	16. Багш, хөгжмийн боловсрол**	· Монгол хэл · Англи хэл · Нийгэм судлал	· Ур чадварын шалгалт	
125.	17. Багш, мэдээлэл зүйн боловсрол**	· Математик · Физик	· Ур чадварын шалгалт	
126.	18. Багш, бага боловсрол**	· Монгол хэл · Математик	· Ур чадварын шалгалт	
МУИС-ийн БАРУУН БҮСИЙН СУРГУУЛЬ				
127.	1. Нягтлан бодох бүртгэл	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	430
128.	2. Санхүү, банк	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	
129.	3. Эрх зүй	· Нийгэм судлал	· Математик · Англи хэл	
130.	4. Программ хангамж**	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
131.	5. Барилгын инженерчлэл	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
132.	6. Цахилгааны инженерчлэл	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
133.	7. Уул уурхайн ашиглалтын технологи*	· Математик · Физик	· Англи хэл · Газарзүй	
134.	8. Химийн боловсруулалтын технологи	· Хими · Физик · Математик	· Биологи · Англи хэл	
135.	9. Аялал жуулчлал**	· Газарзүй · Англи хэл · Математик	· Ур чадвар	
136.	10. Гадаад хэлний орчуулга (Хятад)	· Англи хэл · Орос хэл · Математик	· Нийгэм судлал · Монгол хэл · Түүх	

137.	11. Нийгмийн ажил**	· Нийгэм судлал · Англи хэл	· Монгол хэл · Математик
138.	12. Нийгмийн эрүүл мэнд	· Биологи · Англи хэл	· Хими · Нийгэм судлал
139.	13. Ойн аж ахуй*/**	· Хими · Биологи · Физик	· Математик · Нийгэм судлал
140.	14. Сэтгэл судлал**	· Нийгэм судлал · Математик	· Монгол хэл · Англи хэл
141.	15. Экологи	· Биологи · Математик	· Хими · Нийгэм судлал
142.	16. Багш, дизайн технологийн боловсрол	· Нийгэм судлал · Математик · Монгол хэл	· Ур чадварын шалгалт
143.	17. Багш, биеийн тамирын боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадварын шалгалт
144.	18. Багш, сургуулийн өмнөх боловсрол**	· Монгол хэл · Нийгэм судлал · Математик	· Ур чадварын шалгалт
145.	19. Багш, хөгжмийн боловсрол**	· Монгол хэл · Англи хэл · Нийгэм судлал	· Ур чадварын шалгалт
146.	20. Багш, бага боловсрол**	· Монгол хэл · Математик	· Ур чадварын шалгалт
147.	21. Багш, мэдээлэл зүйн боловсрол**	· Математик · Физик	· Ур чадварын шалгалт
148.	22. Багш, математикийн боловсрол**	· Математик · Физик	· Ур чадварын шалгалт
149.	23. Багш, физикийн боловсрол**	· Физик · Математик	· Ур чадварын шалгалт
150.	24. Багш, биологийн боловсрол**	· Биологи · Хими	· Ур чадварын шалгалт
151.	25. Багш, гадаад хэлний боловсрол (Англи)	· Англи хэл · Орос хэл · Монгол хэл	· Ур чадварын шалгалт
152.	26. Багш, гадаад хэлний боловсрол (Орос)	· Англи хэл · Орос хэл · Монгол хэл	· Ур чадварын шалгалт
153.	27. Багш, газарзүйн боловсрол**	· Газарзүй · Нийгэм судлал · Математик	· Ур чадварын шалгалт



154.	28. Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол	· Монгол хэл · Нийгэм судлал	· Ур чадварын шалгалт	
155.	29. Багш, нийгмийн ухааны боловсрол	· Нийгэм судлал · Түүх	· Ур чадварын шалгалт	
156.	30. Багш, химийн боловсрол**	· Хими · Биологи · Математик	· Ур чадварын шалгалт	
БҮРЭЛДЭХҮҮН/САЛБАР СУРГУУЛИЙН ХАМТАРСАН ХӨТӨЛБӨРҮҮД				
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ МУИС-ийн БИЗНЕС, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ болон БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН ХАМТАРСАН хөтөлбөр				
157.	1. Нягтлан бодох бүртгэл	· Математик	· Англи хэл, · Нийгэм судлал	490
158.	2. Санхүү, банк	· Математик	· Англи хэл · Нийгэм судлал	
159.	3. Даатгал	· Математик	· Англи хэл, · Нийгэм судлал	
160.	4. Маркетинг	· Математик	· Англи хэл, · Нийгэм судлал	
161.	5. Менежмент	· Математик	· Англи хэл, · Нийгэм судлал	
162.	6. Худалдаа	· Нийгэм ,,,судлал	· Монгол хэл · Англи хэл	
163.	7. Зочлох үйлчилгээ	· Нийгэм ,,,судлал	· Монгол хэл · Түүх	
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ МУИС-ийн БИЗНЕС, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ болон УЛС ТӨР СУДЛАЛ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛИЙН ХАМТАРСАН 2+2 хөтөлбөр**				
164.	1. Нийтийн удирдлага	· Нийгэм судлал · Математик	· Англи хэл · Нийгэм судлал	490
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ МУИС-ийн БИЗНЕС, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ болон МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ЭЛЕКТРОНИКИЙН СУРГУУЛИЙН ХАМТАРСАН 1+3 хөтөлбөр*				
165.	1. Программ хангамж**	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	490

166.	2. Мэдээллийн технологи*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
167.	3. Компьютерын ухаан*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
168.	4. Мэдээллийн систем	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
169.	5. Статистик*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
170.	6. Электроникийн инженерчлэл*	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
171.	7. Компьютерын сүлжээ	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
172.	8. Холбооны технологи	· Математик · Физик	· Нийгэм судлал · Англи хэл	
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ МУИС-ийн БИЗНЕС, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ болон ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛИЙН ХАМТАРСАН 1+3 хөтөлбөр*				
173.	1. Хүрээлэн буй орчин судлал	· Хими · Математик	· Биологи · Нийгэм судлал	490
174.	2. Ойн аж ахуй*/**	· Хими · Биологи · Физик	· Математик · Нийгэм судлал	
МУИС-ийн ЗҮҮН БҮСИЙН СУРГУУЛЬ болон ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛИЙН ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР				
175.	1. Ашигт малтмалын баяжуулалтын технологи*	· Хими · Физик · Математик	· Нийгэм судлал · Газарзүй	490
МУИС-ийн ЗҮҮН БҮСИЙН СУРГУУЛЬ болон ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН 2+2 ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР				
176.	1. Сэтгэл судлал**	· Нийгэм судлал · Математик	· Монгол хэл · Англи хэл	490
177.	2. Цаг уур судлал	· Математик · Физик · Газарзүй	· Нийгэм судлал · Англи хэл · Монгол хэл	

* Дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэл

** Дээд боловсролын эрэлттэй мэргэжлийн чиглэл

ОЛОН УЛС, УЛСЫН ОЛИМПИАДЫН НӨХЦӨЛӨӨР ЭЛСҮҮЛЭХ ЖАГСААЛТ

№	Бүрэлдэхүүн сургууль/салбар	Олимпиадын чиглэл нь ("Суурь" шалгалтад заагдсан хичээл байна)	ОУ-ын олимпиад элсүүлэх нөхцөл	Улсын олимпиад элсүүлэх нөхцөл
1.	Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Биологи • Газарзүй • Математик • Физик • Хими 	Оролцогч	Оролцогч
2.	Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Математик • Нийгэм судлал • Түүх • Англи хэл 	Эхний 3 байрт шалгарсан	Онооны эрэмбээр 1-ээс 3-рт жагссан
3.	Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Монгол хэл • Орос хэл • Түүх • Математик • Нийгэм судлал 	Оролцогч	Оролцогч
4.	Мэдээллийн технологи, электроникийн сургуулийн хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Математик • Физик • Мэдээлэл зүй 	Эхний 3 байр, тусгай байрт шалгарсан	Онооны эрэмбээр 1-ээс 6-рт жагссан
5.	Инженер, технологийн сургуулийн хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Биологи • Газарзүй • Математик • Физик • Хими 	Оролцогч	Оролцогч
6.	Бизнесийн сургуулийн хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Математик 	Эхний 3 байрт шалгарсан	Онооны эрэмбээр 1-ээс 3-рт жагссан
7.	Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Орос хэл • Математик • Нийгэм судлал 	Эхний 3 байрт шалгарсан	Онооны эрэмбээр 1-ээс 3-рт жагссан

8.	Хууль зүйн сургуулийн хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Нийгэм судлал 	Эхний 3 байрт шалгарсан	Онооны эрэмбээр 1-ээс 3-рт жагссан
9.	Завхан аймаг дахь МУИС-ийн бизнес, мэдээллийн технологийн сургуулийн хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Математик • Нийгэм судлал • Физик • Хими • Газарзүй 	Оролцогч	Оролцогч
10.	МУИС-ийн зүүн бүсийн сургуулийн хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Орос хэл • Математик • Монгол хэл • Нийгэм судлал • Физик 	Оролцогч	Оролцогч
11.	МУИС-ийн баруун бүсийн сургуулийн хөтөлбөрүүд	<ul style="list-style-type: none"> • Англи хэл • Математик • Монгол хэл • Нийгэм судлал • Физик • Хими 	Оролцогч	Оролцогч


Хүснэгт 3

**“МУИС-ИЙН ОРОН НУТГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ” АНГИЛЛААР
ЭЛСЭГЧИЙН СОНГОХ ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ**

№	Бүрэлдэхүүн, салбар сургууль	Хөтөлбөр
1.	Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар	Биологи*
2.		Газар зүй*
3.		Физик*
4.		Хими*
5.		Биохими
6.		Экологи
7.		Биологийн нөөц судлал
8.		Хэрэглээний хими
9.		Геологи*
10.		Геофизик
11.		Байгаль орчны зайнаас тандан судлал
12.		Цаг уур судлал
13.		Ус судлал
14.		Физик электроник
15.		Микробиологи

* Дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэл

** Дээд боловсролын эрэлттэй мэргэжлийн чиглэл



УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны А/143 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”-ын 3.2.3-3.2.6 дахь заалт, Боловсролын сайдын 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Босго оноо тогтоох тухай” А/34 дугаар тушаалыг үндэслэж, “Монгол Улсын Их Сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2026-2027 оны хичээлийн жилийн намрын улиралд оюутан элсүүлэх журам”-ын Хүснэгт 1-д заасан ур чадварын шалгалттай хөтөлбөрт элсэх хүсэлт гаргасан бүртгүүлэгчээс ур чадварын шалгалт авах, ур чадварын шалгалт зохион байгуулагчдыг мэдээллээр хангах, үйл ажиллагааг чиглүүлэхэд оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

МУИС-ийн элсэлтийн бүртгэлд Ур чадварын шалгалт шаардсан хөтөлбөрт бүртгүүлсэн бүрэн дунд боловсролтой иргэн хамрагдана.

ГУРАВ. ШАЛГАЛТЫН КОМИСС, ТҮҮНИЙ ҮҮРЭГ

Ур чадварын шалгалтын комиссыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын тушаалаар томилно. Комисс нь ур чадварын шалгалтыг бүрэн хариуцаж зохион байгуулна. Ур чадварын шалгалтын комисс холбогдох мэргэжлийн тэнхимийн 3-аас дээш жил ажиллаж байгаа багш нараас бүрдэнэ. Ур чадварын шалгалтыг томилогдсон комисс бүрэн бүрэлдэхүүнтэй байж авна.

Ур чадварын шалгалтын комисс нь анхны оноог хэмжээст оноо руу тооцоолж шалгалтын дүнг элсэлтийн комисс болон Цахим шилжилтийн газарт хүргүүлнэ.

ДӨРӨВ. ХУГАЦАА, БАЙРШИЛ

ШУС-ийн багш бэлтгэх хөтөлбөрүүдийн ур чадварын шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 15:00 цагт, НУС-ын “Сэтгүүл зүй” хөтөлбөрийн ур чадварын шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 16:30 цагт, БУС-ын “Аялал жуулчлал” хөтөлбөрийн ур чадварын шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 29-ний 18.00 цагт цахимаар авна. Ур чадварын шалгалтын мэдээллийг элсэлтийн системд бүртгэгдсэн цахим шуудан, холбоо барих дугаараар хүргэнэ. Орон нутгийн салбар сургуулийн ур чадварын шалгалтын товыг тухайн салбар сургууль гаргана.


Орон нутаг дахь салбар сургуулийн ур чадварын шалгалтыг тухайн сургууль дээр зохион байгуулна. Орон нутаг дахь салбар сургуулиуд ур чадварын шалгалт авах нэмэлт удирдамж гаргаж болно.

ТАВ. ШАЛГАЛТЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Ур чадварын шалгалтыг элсэн суралцах хөтөлбөрийн онцлогтой уялдуулан бичгийн ажил, тест, ярилцлага, кейс ажиллуулах, зөөлөн ур чадвар, хүүхэдтэй ажиллах ур чадвар, хандлага, төлөвшил (хүүхэдтэй ажиллах, тэднийг хайрлах, ойлгох мэдрэмж, харилцах эв дүй)-ийг тогтоох тест, багш болох сонирхол, натюрморт зурах, сэдэвт зохиомж зурах, дуулах, бүжиглэх, хөгжимдөх, жүжиглэх, эсээ бичих, видео танилцуулга, сонсгол,

хэмнэл шалгах, сэтгэц зан үйлийн байдал, бие бялдрын бэлтгэгдсэн байдал, асуумж зэрэг хэлбэрээр авч, шалгуулагчийн ур чадварыг үнэлнэ.

Ур чадварын шалгалт авахдаа тухайн ур чадварын шалгалтын комисс тодорхой бэлтгэлийг хангаж, шалгалт өгөх иргэнд шаардлагатай мэдээллийг урьдчилан хүргэж ажиллана. Шалгуулагч нь биеийн байцаалт болон шалгалт өгөхтэй холбоотойгоор өөрийгөө бэлдэнэ.



ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Хоёр хэсгээс бүрдэх шалгалтад бүртгүүлсэн элсэгчийн тооноос хамаарч тест авах болон бодит материал бэлтгэх, ангиудад хуваарилах, хуваарилсан ерөөнд элсэгчдийг шифрлэх ажлыг шалгалтын комисс зохион байгуулна.
- Шалгалтын материалыг шалгалтын комисс урьдчилан боловсруулж, шифрлэж, олшруулан, тусгай хавтсанд битүүмжилсэн байна.
- Шалгалтын материал задарсан, битүүмж алдагдсан тохиолдолд тухайн шалгалтыг зохион байгуулж байгаа комисс хариуцлага хүлээнэ.
- Ур чадварын шалгалт авах хэлбэрийг шалгалтын комисс шийдвэрлэнэ.
- Ур чадварын шалгалт авахдаа хөндлөнгийн хянагч шалгалтын үеэр байлцуулж болно.
- Ур чадварын шалгалт авч шаардлага хангасан элсэгчийг элсүүлнэ.
- Ур чадварын шалгалтын хэмжээст оноог дагалдах шалгалтын оноогоор тооцно. Оноог тус журмын 5.5-д заасан аргачлалаар тооцоолно.
